



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 02 сарын 13 өдөр

Дугаар А/76

Булган сум

Гэрээ шууд байгуулах
эрх олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.2 дахь заалт, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар хуралдааны XII/21 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Булган аймгийн төрийн байгууллагуудад ашиглагдах хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод удирдлагын нэгдсэн цахим системийг 135 000 000 (нэг зуун гучин таван сая) төгрөгөөр “Ухаалаг Засаглал” ТББ-тай хууль, журмын хүрээнд гэрээ байгуулж, хяналт тавьж хүлээн авахыг Засаг даргын Тамгын газар (Д.Алтаншагай)-т үүрэг болгосугай.

2. Санхүүжилтийг орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын батлагдсан төсөл арга хэмжээнээс санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Батцогт)-д зөвшөөрсүгэй.

3. Биет бус хөрөнгийг бүртгэлжүүлж тайлагнахыг Засаг даргын тамгын газар (Д.Алтаншагай)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

6323010018